



МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2017 оны 02 сарын 09 өдөр

Дугаар А/29

Улаанбаатар хот

Дотоод аудитын хорооны бүрэлдэхүүнийг
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын “Төсвийн тухай хууль” –ийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 4 дүгээр зүйлийн 4.12, 4.13, 4.14 дэх заалт, Сангийн сайдын 2013 оны 29 дүгээр тушаалаар батлагдсан “Дотоод аудитын хорооны дүрэм” -ийн 2 дугаар зүйлийн 2.2, 2.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын дэргэдэх Дотоод аудитын хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Хорооны дарга:	Д.Оюунхорол	Сайд
Гишүүд	Ц.Цэнгэл	Төрийн нарийн бичгийн дарга
	Т.Булган	Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга
	Х.Батжаргал	Төрийн захиргаа удирдлагын газрын дарга
	Т.Алтангэрэл	Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга
	Б.Эрдэнэ	“Монголын байгаль орчны” Иргэний зөвлөлийн тэргүүн
	Д.Отгонцэцэг	“Монголын үйлдвэрлэлийн гидрогеологчдийн холбоо” Төрийн бус байгууллагын гишүүн
Нарийн бичгийн дарга	Ц.Пүрэвмаа	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын мэргэжилтэн

2. Дотоод аудитын хорооны хуралдааныг шаардлагатай үед шуурхай зохион байгуулж, хуралдааны шийдвэрийн хэрэгжилтийг хангаж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга /Т.Алтангэрэл/-д үүрэг болгосугай.

3. Уг тушаал гарсантай холбогдуулан 2016 оны 09 сарын 02 өдрийн А/29 тоот тушаалыг хүчингүйд тооцсугай.

САЙД



Д.ОЮУНХОРОЛ

100077



МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2017 оны 12 сарын 04 өдөр

Дугаар А/333

Улаанбаатар хот

Дотоод аудитын хорооны
бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 4 дүгээр зүйлийн 4.12, 4.13, 4.14 дэх заалт, Сангийн сайдын 2013 оны 29 дүгээр тушаалаар батлагдсан “ Дотоод аудитын хорооны дүрэм” -ийн 2 дугаар зүйлийн 2.1, 2.2, 2.3, 2.4 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын дэргэдэх Дотоод аудитын хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Гишүүд	Ц.Цэнгэл	Төрийн нарийн бичгийн дарга
	Х.Батжаргал	Төрийн захиргааны удирдлагын газрын дарга
	Ч.Батсансар	Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газрын дарга
	Т.Алтангэрэл	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга
	Б.Батжаргал	“Астериск техноложис” ХХК-ийн санхүүгийн зөвлөх
	Ц.Ичинхорлоо	“Хаппи бьюлдинг” ХХК-ийн ерөнхий нягтлан бодогч
Нарийн бичгийн дарга	Л.Оюунчимэг	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах мэргэжилтний түр орлон гүйцэтгэгч

2. Дотоод аудитын хорооны хуралдааныг шаардлагатай үед шуурхай зохион байгуулж, хуралдааны шийдвэрийн хэрэгжилтийг хангаж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга /Т.Алтангэрэл/-д үүрэг болгосугай.

3. Уг тушаал гарсантай холбогдуулан 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн А/29 дүгээр тушаалыг хүчингүйд тооцсугай.

САЙД



Н.ЦЭРЭНБАТ